

**НҮБ-ын Олон Улсын Худалдааны Эрхийн Комиссийн Арбитрын  
Дүрэм  
(2010 онд шинэчилсэн найруулга)**

**1 дүгээр бүлэг. Дүрмийн танилцуулга**

**1 дүгээр зүйл. Хэрэглэх хүрээ**

1. Хэрэв талууд гэрээнээс үүссэн эсэхээс үл хамааран тодорхой эрх зүйн харилцаанаас үүссэн аливаа маргааныг НҮБ-ын Олон Улсын Худалдааны Эрхийн Комиссийн Арбитрын дүрмийн дагуу арбитраар шийдвэрлүүлнэ гэж тохиролцсон бол маргааныг энэ Дүрмийн дагуу шийдвэрлүүлэх бөгөөд энэ тохиолдолд талууд Дүрэмд тодорхой өөрчлөлт оруулахыг тохиролцож болно.

2. Талууд Дүрмийн өөр хувилбарыг хэрэглэнэ гэж тохиролцоогүй бол 2010 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн дараа байгуулсан арбитрын хэлэлцээрийн талууд арбитрын ажиллагаа эхлэх өдөр хүчин төгөлдөр байсан Дүрмийн дагуу арбитрын ажиллагааг явуулахаар болсон гэж тооцно. 2010 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн дараа энэ өдрөөс өмнө гаргасан саналыг хүлээн авснаар байгуулсан арбитрын хэлэлцээрийн хувьд энэ нөхцөл хамаарахгүй.

3. Арбитрын ажиллагаанд хамаарах, талуудын зөрчиж үл болох хуулийн заалтыг зөрчсөн тохиолдолд тухайн хуулийн заалт үйлчлэх бөгөөд үүнээс бусад тохиолдолд энэ Дүрэм нь арбитрын ажиллагааг зохицуулна.

**2 дугаар зүйл. Хугацааг мэдээлэх болон тоолох**

1. Мэдээлэл, харилцаа холбоо эсвэл санал зэрэг мэдэгдлийг бүртгэх боломжоор хангагдсан аливаа харилцаа холбоогоор хүргүүлж болно.

2. Хэрэв тусгайлан энэ зорилгоор аль нэг тал хаягийг өгсөн эсвэл арбитрын бүрэлдэхүүнээс эрх олгосон бол энэ хаяг руу тухайн талд мэдэгдэлийг хүргүүлэх бөгөөд ийнхүү хүргүүлсэн болон мэдэгдлийг хүлээн авсанд тооцно. Факс эсвэл электрон шуудан зэрэг электрон холбоон хүргэлтийг гагцхүү тусгайлан өгсөн буюу эрх мэдэл олгосон хаяг руу хүргүүлж болно.

3. Ингэж өгөөгүй эсвэл эрх мэдэл олгоогүй бол мэдэгдлийг:

(a) Хүлээн авагч талд биеэр хүргүүлсэн бол; эсвэл

(b) Хүлээн авагчийн аж ахуйн байгууллага, байнгын оршин суугаа газарт буюу түүний шуудангийн хаягаар хүргүүлсэн бол хүлээн авсанд тооцно.

4. Хэрэв ухаалаг лавламжийн аргаар хүргэлтийг энэ зүйлийн 2 эсвэл 3 дахь хэсэгт заасны дагуу илгээж болохгүй бол мэдэгдлийг хүлээн авагчийн хамгийн сүүлд мэдэгдэж байсан аж ахуйн байгууллага, байнгын оршин суугаа газарт буюу шуудангийн хаягаар баталгаат захиа болон хүргэх оролдлогын тэмдэглэл үйлдэгдсэн бусад аргаар хүргэсэн байвал хүлээн авсанд тооцно.

5. Мэдэгдлийг энэ зүйлийн 2, 3, эсвэл 4 дэх хэсэгт заасны дагуу хүргэсэн өдрийг эсвэл энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу хүргэх оролдлого хийгдсэн өдрийг хүлээн авсан өдөрт тооцно. Арбитрын ажиллагааны мэдэгдлийг электрон холбоогоор хүргүүлэхэд гагцхүү хүлээн авагчийн электрон шуудангийн хаягт хүрсэн өдрийг хүлээн авсанд тооцох бөгөөд үүнээс бусад тохиолдолд электрон холбоогоор хүргүүлсэн мэдэгдлийг илгээсэн өдрийг хүлээн авсан өдөрт тооцно.

6. Энэ Дүрмийн дагуу хугацааг тоолоход энэ хугацаа нь мэдэгдлийг хүлээн авсан өдрийн дараагийн өдрөөс эхэлнэ. Хэрэв энэ хугацааны сүүлийн өдөр нь нийтээр амрах баярын өдөр эсвэл хүлээн авагчийн оршин суугаа газар буюу аж ахуйн байгууллагын амралтын өдөр бол энэ хугацаа амралтын дараагийн эхний ажлын өдөр хүртэл сунгагдана. Хугацаа тоологдож байгаа үед тохиосон нийтээр амрах баярын өдөр эсвэл ажлын бус өдөр зэрэг нь хугацааг тоолоход орно.

### **3 дугаар зүйл. Арбитрын ажиллагааны тухай мэдэгдэл**

1. Арбитрын ажиллагааг эхлүүлж байгаа аль нэг тал эсвэл талууд (цаашид “нэхэмжлэгч” гэх) нөгөө тал эсвэл талуудад (цаашид “хариуцагч” гэх) арбитрын ажиллагааны мэдэгдлийг хүргүүлнэ.

2. Арбитрын ажиллагааг арбитрын ажиллагааны тухай мэдэгдлийг хариуцагч хүлээн авсан өдрөөс эхэлсэн гэж тооцно.

3. Арбитрын ажиллагааны мэдэгдэлд дараах зүйлийг тусгана:

- (a) Маргааныг арбитрт шилжүүлэх тухай шаардлага;
- (b) Талуудын нэр, хаяг;
- (c) Үндэслэл болсон арбитрын хэлэлцээр;
- (d) Маргаан үүссэн эсвэл холбогдон гарсан аливаа гэрээ буюу бусад эрх зүйн баримт бичиг, эсвэл ийм гэрээ буюу баримт бичиг байхгүй тохиолдолд үүнд хамаарах харилцааны талаарх товч танилцуулга;
- (e) Нэхэмжлэлийн товч тайлбар болон үүнд хамаарах аливаа үнийн дүнгийн талаарх мэдээлэл;
- (f) Нэхэмжилж буй зүйлс;
- (g) Хэрэв талууд өмнө нь тохиролцоогүй бол арбитрчдын тоо, хэл болон арбитрын ажиллагаа явуулах газрын талаарх санал.

4. Арбитрын ажиллагааны мэдэгдэлд дараах зүйлсийг оруулж болно:

- (a) 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан томилох эрх бүхий этгээдийг томилох тухай санал;
- (b) 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу нэг арбитрчийг томилох

тухай санал;

- (c) 9 эсвэл 10 дугаар зүйлд заасны дагуу арбитрчийг томилсон тухай мэдэгдэл.

5. Арбитрын бүрэлдэхүүнийг байгуулахад арбитрын ажиллагааны талаарх мэдэгдэл хангалттай эсэхтэй холбоотой аливаа маргаан саад болохгүй бөгөөд энэ асуудлыг арбитрын бүрэлдэхүүн эцэслэн шийдвэрлэнэ.

#### **4 дүгээр зүйл. Арбитрын ажиллагааны мэдэгдлийн хариу**

1. Хариуцагч арбитрын ажиллагааны талаарх мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор нэхэмжлэгчид арбитрын ажиллагааны талаарх мэдэгдлийн хариуг хүргүүлнэ. Үүнд дараах зүйлийг оруулна:

- (a) Хариуцагч тус бүрийн нэр, хаяг;
- (b) 3 дугаар зүйлийн 3 дугаар хэсгийн “с”-ээс “g” хүртэл заасны дагуу арбитрын ажиллагааны мэдэгдэлд агуулагдсан мэдээлэлд хариу өгнө.

2. Арбитрын ажиллагааны мэдэгдлийн хариуд дараах зүйлийг тусгаж болно. Үүнд:

- (a) Энэ Дүрмийн дагуу байгуулагдах арбитрын бүрэлдэхүүнд маргааныг шийдвэрлэх харьяалал байхгүй гэсэн аливаа гомдол;
- (b) 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан томилох эрх бүхий этгээдийг томилох тухай санал;
- (c) 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан нэг арбитрчийг томилох тухай санал;
- (d) 9 эсвэл 10 дугаар зүйлд заасан арбитрчийг томилох тухай мэдэгдэл;
- (e) Аливаа сөрөг нэхэмжлэл эсвэл суутган тооцуулах зорилготой нэхэмжлэл болон үүнд хамаарах бол маргааны үнийн дүн болон нэхэмжилж буй зүйлс;
- (f) Хариуцагч арбитрын хэлэлцээрийн нэхэмжлэгчээс өөр талын эсрэг нэхэмжлэлийг гаргасан тохиолдолд 3 дугаар зүйлд заасны дагуу арбитрын ажиллагааны тухай мэдэгдэл.

3. Арбитрын бүрэлдэхүүнийг байгуулахад хариуцагчийн арбитрын ажиллагааны тухай мэдэгдэлд хариу өгөөгүй эсвэл арбитрын ажиллагааны тухай мэдэгдэлд дутуу эсвэл хугацаа хэтэрч хариу өгөх аливаа асуудал маргаан болохгүй бөгөөд эдгээрийг арбитрын бүрэлдэхүүн эцэслэн шийдвэрлэнэ.

### **5 дугаар зүйл. Төлөөлөл болон туслалцаа**

Талууд өөрсдийн сонгосон хүнээр төлөөлүүлж эсвэл туслалцаа авч болно. Эдгээр хүмүүсийн нэр, хаягийг талууд болон арбитрын бүрэлдэхүүнд мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдэхдээ тухайн томилгоо нь төлөөлөл эсвэл туслалцаа авах зорилготойгоор хийгдсэн эсэхийг тодорхойлно. Хэрэв тухайн хүн аль нэг талын төлөөлөгчөөр ажиллах бол арбитрын бүрэлдэхүүн өөрийн санаачилгаар эсвэл аль нэг талын хүсэлтээр ямар ч үед төлөөлөгчид олгогдсон эрх мэдлийг гэрчлэх нотлох баримтыг арбитрын бүрэлдэхүүнээс тогтоосон хэлбэрт оруулж үзүүлэхийг шаардаж болно.

### **6 дугаар зүйл. Томилох эрх бүхий этгээд**

1. Талууд томилох эрх бүхий байгууллагыг харилцан тохиролцоогүй бол аль нэг тал ямар ч үед Гааг дахь Арбитрын байнгын шүүхийн (цаашид “АБШ” гэх) Ерөнхий нарийн бичгийн дарга зэрэг нэг эсвэл түүнээс дээш байгууллага эсвэл хүний нэр(с)-ийг санал болгож болох бөгөөд эдгээрээс нэг нь томилох эрх бүхий этгээдийн үүргийг гүйцэтгэнэ.

2. Хэрэв талууд томилох эрх бүхий этгээдийн сонголтонд талуудын энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан саналыг гаргаснаас хойш 30 хоногийн дотор харилцан санал нэгдээгүй бол аль нэг тал АБШ-ийн Ерөнхий нарийн бичгийн даргад томилох эрх бүхий этгээдийг томилох тухай хүсэлт гаргаж болно

3. Дүрмийн дагуу аль нэг тал асуудлыг тодорхой хугацаанд томилох эрх бүхий этгээдэд өгөх шаардалагатай бөгөөд томилох эрх бүхий этгээдийг харилцан тохиролцоогүй эсвэл томилоогүй байгаа бол аль нэг тал томилох эрх бүхий этгээдийг харилцан тохиролцоо эсвэл томилох журмыг эхлүүлэхээр тохиролцсон хугацаанаас эхэлж энэ тохиролцоо, томилгоо болох хүртэл хугацааг хойшлуулна.

4. 41 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд хэрэв томилох эрх бүхий этгээд үйлдэл хийхээс татгалзаж байгаа эсвэл аль нэг талын хүсэлтийг авснаас хойш 30 хоногийн дотор арбитрчийг томилоогүй бөгөөд энэ Дүрэмд заасны дагуу үйлдэл хийхгүй байгаа, эсвэл аль нэг талын хүсэлтийг хүлээн авснаас хойш үндэслэлтэй хугацаанд арбитрчийг татгалзан гаргах асуудлаар шийдвэр гаргахгүй байгаа бол аль нэг тал АБШ-ийн Ерөнхий нарийн бичгийн даргад томилох эрх бүхий этгээдийг нөхөн томилох тухай хүсэлтийг гаргаж болно.

5. Энэ Дүрмийн дагуу чиг үүргээ хэрэгжүүлж байх явцад томилох эрх бүхий этгээд болон АБШ-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга аль нэг тал болон арбитрчдаас шаардлагатай гэсэн мэдээллийг хүсэж болох бөгөөд талуудад болон шаардлагатай бол арбитрчдад өөрийн тогтоосон хэлбэрээр саналаа илэрхийлэх боломж олгоно. Томилох эрх бүхий этгээд болон АБШ-ийн Ерөнхий нарийн бичгийн даргаас ирсэн буцсан аливаа харилцаа холбоог илгээгч этгээдээс талуудад мэдэгдэнэ.

6. Томилох эрх бүхий этгээд нь 8, 9, 10, 14 дүгээр зүйлд заасныг үндэслэн арбитрчийг томилох хүсэлт авсан бол хүсэлт гаргасан тал нь томилох эрх бүхий байгууллагад арбитрын ажиллагааг эхлүүлэх мэдэгдэл болон хэрэв байгаа бол

тухайн мэдэгдлийн хариу мэдэгдлийн хуулбарыг томилох эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

7. Томилох эрх бүхий этгээд нь бие даасан, хараат бус арбитрчийн томилгоог баталгаажуулах асуудлыг авч үзэх бөгөөд талуудын иргэний харьяалалаас өөр иргэний харьяалалтай арбитрчийг томилохыг илүүд үзнэ.

## **Хоёрдугаар бүлэг. Арбитрын бүрэлдэхүүнийг байгуулах**

### **7 дугаар зүйл. Арбитрчдын тоо**

1. Хэрэв талууд арбитрчийн тоог харилцан тохиролцоогүй бөгөөд арбитрын ажиллагааны хүсэлтийг хариуцагч хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор талууд нэг арбитрчтай байхаар тохиролцож чадаагүй бол гурав арбитрчийг томилно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийг үл харгалзан хэрэв энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааны дотор аль нэг тал нөгөө талын нэг арбитрчийг томилох тухай хүсэлтэд хариу өгөөгүй бөгөөд 9 эсвэл 10 дугаар зүйлд заасны дагуу аль нэг тал эсвэл талууд хоёр дахь арбитрчийг томилоогүй бол томилох эрх бүхий этгээд хэргийн нөхцөл байдлыг харгалзан илүү тохиромжтой гэж үзвэл аль нэг талын хүсэлтээр 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмын дагуу нэг арбитрчийг томилж болно.

### **Арбитрчийг томилох (8-аас 10 дугаар зүйл заалтууд)**

#### **8 дугаар зүйл**

1. Хэрэв талууд нэг арбитрчийг томилохоор харилцан тохиролцсон бөгөөд талууд нэг арбитрчийг томилох тухай саналыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор харицан тохиролцолд хүрч чадаагүй бол аль нэг талын хүсэлтээр томилох эрх бүхий этгээд нэг арбитрчийг томилно.

2. Томилох эрх бүхий этгээд нэн даруй нэг арбитрчийг томилно. Энэ томилгоог хийхдээ талууд жагсаалтын дагуух журмыг хэрэглэж болохгүй гэдэг дээр санал нэгдсэн эсвэл томилох эрх бүхий этгээд өөрийн үзэмжээр тухайн хэрэгт жагсаалтын дагуух журам тохиромжгүй гэж үзсэнээс бусад тохиолдолд томилох эрх бүхий этгээд дараах жагсаалтын дагуух журмыг хэрэглэнэ. Үүнд:

- (a) Томилох эрх бүхий этгээд талууд тус бүрт хамгийн багадаа гурван нэрийг багтаасан ижил жагсаалтыг хүргүүлнэ;
- (b) Энэ жагсаалтыг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор талууд тус бүр өөрийн татгалзсан нэр(с)-ийг дарж, үлдсэн нэрсийг ач холбогдлоор нь дугаарласны дараа жагсаалтыг томилох эрх бүхий этгээдэд буцааж өгч болно;
- (c) Дээрх хугацаа дуусгавар болсны дараа томилох эрх бүхий этгээд талуудаас буцаан авсан жагсаалтад дэмжигдсэн нэрс дундаас болон тэдгээрийн сонгогдсон дарааллыг нь харгалзан нэг

арбитрчийг жагсаалтаас томилно;

- (d) Хэрэв ямар нэг шалтгааны улмаас энэ журмаар арбитрачийг томилох боломжгүй бол томилох эрх бүхий этгээд нэг арбитрачийг өөрийн үзэмжээр томилж болно.

*9 дүгээр зүйл*

1. Хэрэв гурван арбитрачийг томилох тохиолдолд талууд тус бүр нэг арбитрачийг томилно. Томилогдсон хоёр арбитрач гурав дахь арбитрачийг тохиролцон томилох бөгөөд ийнхүү томилогдсон гурав дахь арбитрач арбитрарын хуралдааныг даргална.
2. Аль нэг тал нь арбитрач томилох тухай нөгөө талын хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор өөрийн талын арбитрачийг томилсон тухай нөгөө талдаа мэдэгдээгүй бол сонирхогч тал томилох эрх бүхий этгээдээс хоёр дахь арбитрачийг томилох тухай хүсэлт гаргаж болно.
3. Хэрэв хоёр дахь арбитрачийг томилсноос хойш 30 хоногийн дотор хоёр арбитрач даргалагч арбитрачийг тохиролцон томилж чадаагүй бол томилох эрх бүхий этгээд 8 дугаар зүйлд заасан нэг арбитрачийг томилох журмын нэгэн адил даргалагч арбитрачийг томилж болно.

*10 дугаар зүйл*

1. 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасантай нийцүүлэн гурван арбитрачийг томилох бөгөөд нэхэмжлэгч эсвэл хариуцагчаар олон этгээдүүд байгаа бөгөөд талууд арбитрачийг томилох өөр журмыг харилцан тохиролцоогүй бол олон этгээдүүд хамтарч нэхэмжлэгч эсвэл хариуцагчийн хувиар арбитрачийг томилно.
2. Талууд арбитрарын бүрэлдэхүүний тоо нэг эсвэл гурван арбитрачийн тооноос өөр байхаар харилцан тохиролцсон бол арбитрачийг талуудын тохиролцсон журмаар томилно.
3. Энэ Дүрмийн дагуу арбитрарын бүрэлдэхүүнийг байгуулж чадаагүй тохиолдолд томилох эрх бүхий этгээд аль нэг талын хүсэлтээр арбитрарын бүрэлдэхүүнийг байгуулж болох бөгөөд ингэхдээ өмнө нь хийгдсэн аливаа томилгоог хүчингүй болгох, арбитрач тус бүрийг шинээр эсвэл дахин томилох, эдгээрээс аль нэгийг нь даргалагч арбитрачаар томилж болно.

***Арбитрач мэдээллийг ил болгох болон арбитрачийг татгалзан гаргах  
(11 дүгээр зүйлээс 13 дугаар зүйл)***

*11 дүгээр зүйл*

Арбитрачаар ажиллах хүсэлт хүлээн авсан этгээд тухайн маргааныг бие даан, хараат бусаар шийдвэрлэж чадах эсэх талаар өөрт нь үндэслэл бүхий эргэлзээ байвал энэ тухайгаа хүсэлт тавьсан этгээдэд мэдэгдэнэ. Арбитрачаар томилогдсоны дараа буюу арбитрарын ажиллагааны явцад тухайн маргааныг бие даан, хараат бусаар шийдвэрлэж чадах эсэхэд нь эргэлзээ төрүүлэхүйц нөхцөл байдал бий болсон тухай өмнө нь мэдэгдээгүй бол талуудад болон бусад

арбитрчдад энэ тухай нэн даруй мэдэгдэнэ.

*12 дугаар зүйл*

1. Арбитрчийн хараат бус байдал эсвэл бие даасан байдалд эргэлзэх үндэслэл бүхий нөхцөл байдал байгаа тохиолдолд аль ч арбитрчийг татгалзан гаргаж болно.
2. Аль нэг тал нь өөрийн томилсон арбитрчийг гагцхүү томилсоны дараа мэдсэн аливаа шалтгаанаар татгалзан гаргаж болно.
3. Хэрэв арбитрч нь тодорхой үйлдэл хийгээгүй эсвэл хууль зүйн болон бодитойгоор өөрийн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд 13 дугаар зүйлд заасан арбитрчийг татгалзан гаргах журам үйлчилнэ.

*13 дугаар зүйл*

1. Арбитрчийг татгалзан гаргах хүсэлтэй аль нэг тал нь энэ тухай хүсэлтийг татгалзан гаргах арбитрчийг томилсныг мэдсэнээс хойш 15 хоногийн дотор эсвэл 11 болон 12 дугаар зүйлд заасан нөхцөл байдал илэрснийг мэдсэнээс хойш 15 хоногийн дотор арбитрчийг татгалзан гаргах хүсэлтийг сонирхогч тал хүргүүлнэ.
2. Арбитрчийг татгалзан гаргах тухай хүсэлтийг талууд, татгалзан гаргах гэж буй арбитрч болон бусад арбитрчдад мэдэгдэнэ. Татгалзан гаргах тухай хүсэлтэд татгалзан гаргах үндэслэлийг заана.
3. Арбитрчийг ал нэг талаас татгалзан гаргаж байгаа тохиолдолд талууд ийнхүү татгалзан гаргахад санал нэгдэж болно. Арбитрч нь мөн татгалзан гаргах хүсэлтийн дараа ажлаа хүлээлгэн өгч болно. Эдгээрийн аль ч тохиолдолд татгалзан гаргах үндэслэл нь үндэслэлтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөнд тооцохгүй.
4. Хэрэв арбитрчийг татгалзан гаргах тухай хүсэлтийг гаргаснаас хойш 15 хоногийн дотор талууд татгалзан гаргах дээр санал нэгдэхгүй эсвэл татгалзан гаргах гэж байгаа арбитрч ажлаа хүлээлгэн өгөхгүй байгаа бол сонирхогч тал нь арбитрчийг татгалзан гаргах ажиллагааг үргэлжлүүлэхээр шийдэж болно. Энэ тохиолдолд арбитрчийг татгалзан гаргах тухай хүсэлтийг гаргаснаас хойш 30 хоногийн дотор энэ тухай шийдвэрийг томилох эрх бүхий этгээдээс гаргуулж болно.

**14 дүгээр зүйл. Арбитрчийг нөхөн томилох**

1. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр арбитрчийг нөхөн томилох шаардлагатай бол шинэ арбитрчийг 8 дугаар зүйлээс 11 дүгээр зүйлд заасан арбитрчийг томилох эсвэл шинэ арбитрчийг сонгон томилох тухай журмыг баримтлан томилж эсвэл сонгоно. Нөхөн томилох арбитрчийг томилох явцад аль нэг тал тухайн арбитрчийг томилох эсвэл ийнхүү томилоход оролцох эрхээ хэрэгжүүлээгүй тохиолдолд энэ журам нэгэн адил үйлчилнэ.

2. Хэрэв аль нэг талын хүсэлтээр томилох эрх бүхий этгээд нь тухайн хэргийн онцгой нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр аль нэг талд шинэ арбитрчийг томилох эрхийг хасах нь үндэслэлтэй гэж үзвэл томилох эрх бүхий этгээд талуудад болон үлдсэн арбитрчдад саналаа илэрхийлэх боломж олгосны дараа: (а) шинэ арбитрчийг томилох; эсвэл (b) хуралдааныг хаасны дараа бусад арбитрчдад арбитрын ажиллагааг үргэлжлүүлэх, аливаа шийдвэр гаргах эрхийг олгож болно.

**15 дугаар зүйл. Арбитрчийг нөхөн томилсноор хуралдааныг дахин явуулах**

Арбитрын бүрэлдэхүүн өөрөөр шийдвэрлээгүй бол хэрэв арбитрчийг нөхөн томилсон бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өмнөх арбитрч өөрийн үүргээ биелүүлэхийг зогсоосон тэр үеэс эхлүүлэн үргэлжлүүлэн биелүүлнэ.

**16 дугаар зүйл. Хариуцлагаас чөлөөлөгдөх**

Санаатайгаар буруутай үйл ажиллагаа хэрэгжүүлснээс бусад тохиолдолд талууд холбогдох хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнд арбитрчид, томилох эрх бүхий этгээд болон арбитрын бүрэлдэхүүнээс томилсон аливаа этгээдийн эсрэг арбитрын ажиллагаатай холбоотойгоор гарсан аливаа үйлдэл, эс үйлдэхүйн төлөө нэхэмжлэл гаргах эрхээсээ татгалзана.

**Гуравдугаар бүлэг. Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа**

**17 дугаар зүйл. Нийтлэг үндэслэл**

1. Энэ Дүрэмд зааснаар арбитрын бүрэлдэхүүн талуудад тэгш байдлаар хандаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохих шатанд талууд тус бүрт хэргээ танилцуулах боломжоор хангаж арбитрын ажиллагааг шаардлагатай гэж үзсэн хэлбэрээр явуулна. Арбитрын бүрэлдэхүүн эрх хэмжээгээ хэрэгжүүлэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг аль болох хойшлуулах болон шаардлагагүй зардлаас зайлсхийх байдлаар явуулж, талуудын маргааныг шударга, үр дүнтэйгээр шийдвэрлэх байдлыг хангана.

2. Арбитрын бүрэлдэхүүн байгуулагдах болон талуудад саналаа илэрхийлэх боломжийг олгосны дараа арбитрын бүрэлдэхүүн нь аль болох боломжит хугацаанд арбитрын ажиллагааны завсрын хуваарийг тогтооно. Арбитрын бүрэлдэхүүн талуудад саналаа илэрхийлэх боломжийг олгосны дараа аль ч үед энэ Дүрэмд заасан эсвэл талуудын харилцан тохиролцсон хугацааг сунгах эсвэл богиносгож болно.

3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохих шатанд аль нэг тал хүсэлт гаргавал арбитрын бүрэлдэхүүн гэрчийн нотлох баримт танилцуулах, тэр дундаа шинжээч эсвэл амаар мэдүүлэг авахын тулд хэргийг уншиж сонгон явуулна. Ийм хүсэлт гаргаагүй тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн энэ төрлийн хуралдааныг зохион байгуулах эсвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг баримт бичиг болон бусад материал дээр үндэслэн явуулах эсэхийг шийдвэрлэнэ.



4. Аль нэг талын арбитрын бүрэлдэхүүнтэй харилцсан аливаа харилцаа холбоог тухайн тал нь бусад талуудад нэгэн адил мэдэгдэнэ. Ийм харилцааг холбогдох хуулийн дагуу зөвшөөрсөн тохиолдолд арбитрын бүрэлдэхүүнээс өөрөөр шийдвэрлээгүй бол нэг хугацаанд явуулна.

5. Арбитрын бүрэлдэхүүн талуудад, түүний дотор нэмэлт тал болж оролцох гэж байгаа этгээдүүдэд хэргээ танилцуулах боломжоор хангасны дараа аль нэг талд нэмэлт тал болж оруулах явдал нь шударга бус байдал бий болгох тул үүнийг зөвшөөрч болохгүй гэдгийг тогтоосноос бусад тохиолдолд аль нэг талын хүсэлтээр арбитрын хэлэлцээрийн тал болсон нэг эсвэл түүнээс дээш тооны гуравдагч этгээдүүдэд арбитрын ажиллагаанд нэмэлт тал болж оролцохыг зөвшөөрч болно. Арбитрын бүрэлдэхүүн энэ байдлаар арбитрын ажиллагаанд оролцсон бүхий л талуудын хувьд нэг эсвэл хэд хэдэн шийдвэрийг гаргаж болно.

### **18 дугаар зүйл. Арбитрын ажиллагаа явуулах газар**

1. Хэрэв талууд арбитрын ажиллагаа явуулах газрыг харилцан тохиролцоогүй бол хэргийн нөхцөл байдлыг харгалзан арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагаа явуулах газраа тогтооно. Арбитрын шийдвэрийг арбитрын ажиллагаа явуулах газарт гаргасанд тооцно.

2. Арбитрын бүрэлдэхүүн зөвлөлдөх боломжтой ямар ч газар уулзалт товлож болно. Талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн өөр бусад зорилгоор, тухайлбал, хуралдаан явуулах зэрэгт тохиромжтой гэж үзвэл аль ч газар уулзалт хийж болно.

### **19 дүгээр зүйл. Арбитрын ажиллагаа явуулах хэл**

1. Талуудын тохиролцсоныг үндэслэн арбитрын бүрэлдэхүүн томилогдсныхоо дараа нэн даруй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэх арбитрын хэл(үүд)-ийг тогтооно. Энэ шийдвэр нь нэхэмжлэл, хариуцагчийн тайлбар болон бусад бичгэн мэдэгдлүүд болон сонсгол явуулах болох эдгээр хуралдаанд хэрэглэгдэх хэл(үүд)-ийг тодорхойлно.

2. Арбитрын бүрэлдэхүүн нэхэмжлэл болон хариуцагчийн тайлбарт хавсаргаж, эх хэлээр нь ирүүлсэн баримт бичиг болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ирүүлсэн аливаа нэмэлт баримт бичиг буюу бодит нотлох баримтыг талуудын харилцан тохиролцсон эсвэл арбитрын бүрэлдэхүүний тогтоосон хэл(үүд) рүү хөрвүүлсэн орчуулгын хамт ирүүлэхийг шаардаж болно.

### **20 дугаар зүйл. Нэхэмжлэл**

1. Нэхэмжлэгч арбитрын бүрэлдэхүүнээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлээ хариуцагч болон арбитрч тус бүрт бичгээр хүргүүлнэ. Нэхэмжлэгч 3 дугаар зүйлд заасан арбитрын ажиллагааны мэдэгдлийг энэ зүйлийн 2-оос 4 дэх зүйлд заасан шаардлагыг хангасан тохиолдолд үүнийг нэхэмжлэлийн нэгэн адил үзэж болно.

2. Нэхэмжлэлд дараах зүйлийг тусгана. Үүнд:

(a) Талуудын нэр, хяаг;

- (b) Нэхэмжлэлийн үндэслэсэн баримтууд;
- (c) Дэвшүүлж буй асуудлууд;
- (d) Нэхэмжилж буй зүйлс;
- (e) Хууль зүйн үндэслэл эсвэл нэхэмжлэлийг дэмжсэн тайлбар.

3. Маргаан үүссэн эсвэл холбогдон гарах үндэслэл болсон гэрээ эсвэл бусад эрх зүйн баримт бичиг болон арбитрын хэлэлцээрийн хуулбарыг нэхэмжлэлд хавсаргана.

4. Нэхэмжлэлд аль болох нэхэмжлэгчийн үндэслэл болгож буй бүхий л баримт бичиг болон нотлох баримтыг дагалдуулах эсвэл эдгээрийг иш татсан байх шаардлагатай.

### **21 дүгээр зүйл. Хариуцагчийн тайлбар**

1. Хариуцагч арбитрын бүрэлдэхүүнээс тогтоосон хугацаанд тайлбараа нэхэмжлэгч болон арбитрч тус бүрт бичгээр хүргүүлнэ. Хариуцагч 4 дүгээр зүйлд заасан арбитрын ажиллагааны мэдэгдлийн хариуг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг мөн адил хангасан тохиолдолд үүнийг тайлбарын нэгэн адил үзэж болно.

2. Хариуцагчийн тайлбар нь нэхэмжлэлийн “b”-ээс“e”-д заасны дагуу хариуг өгнө (20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг). Хариу тайлбар нь аль болох хариуцагчийн үндэслэл болгосон бүхий л баримт бичиг болон бусад нотлох баримтыг хавсаргах эсвэл эдгээрийг иш татсан байна.

3. Хариуцагчийн тайлбарт буюу хэрэв арбитрын бүрэлдэхүүн тухайн нөхцөл байдлыг харгалзан хойшилсон нь үндэслэлтэй гэж шийдсэн бол арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны сүүлийн шатанд хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргаж болох буюу арбитрын бүрэлдэхүүний эрх хэмжээний асуудал бол суутган тооцуулах зорилготой нэхэмжилд үндэслэж болно.

4. 20 дугаар зүйлийн 2-оос 4 дэх хэсэгт заасан нь сөрөг нэхэмжлэл, 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “f”-д заасан нэхэмжлэл болон суутган тооцох зорилготой нэхэмжлэл зэрэгт хамаарна.

### **22 дугаар зүйл. Нэхэмжлэл эсвэл хариуцагчийн тайлбарт өөрчлөлт оруулах**

Арбитрын бүрэлдэхүүн өөрчлөх эсвэл нэмэлт материалыг хавсаргах нь хугацаа хойшлуулах, нөгөө талд хохиролтой буюу өөр бусад нөхцөл байдлаас хамааран тохиромжгүй гэж үзсэнээс бусад тохиолдолд арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад аль нэг тал өөрийн нэхэмжлэл эсвэл хариуцагчийн тайлбар, үүний дотор сөрөг нэхэмжлэл эсвэл суутган тооцох зорилготой нэхэмжлэлийг өөрчлөх эсвэл үүнд нэмэлт материал хавсаргаж болно. Гэвч нэхэмжлэл эсвэл хариуцагчийн тайлбар тэр дундаа сөрөг нэхэмжлэл эсвэл суутган тооцох

зорилготой нэхэмжлэлийг арбитрын харьяаллалын бус маргаан болгох хэмжээнд засварлах эсвэл нэмэлт оруулж болохгүй.

**23 дугаар зүйл. Арбитрын харьяаллын маргаан мөн эсэх талаарх гомдол гаргах**

1. Арбитрын бүрэлдэхүүн маргааныг арбитрын харьяаллын маргаан мөн эсэхийг өөрөө тогтоох бөгөөд үүнд талууд арбитрын хэлэлцээртэй эсэх, тухайн хэлэлцээр хүчин төгөлдөр эсэхийг тогтооно. Энэ зорилгоор гэрээний нэг хэсэг болсон арбитрын заалтыг гэрээний бусад нөхцлөөс бие даасан гэж үзнэ. Гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзсэн арбитрын бүрэлдэхүүний шийдвэр нь арбитрын заалтыг шууд хүчин төгөлдөр бус болгох үндэслэл болохгүй.

2. Талууд арбитрын бүрэлдэхүүний харьяаллын талаар гомдол гаргахаар бол үндсэн нэхэмжлэлд тайлбар гаргах, эсвэл сөрөг нэхэмжлэл буюу суутган тооцуулах зорилготой нэхэмжлэлийн хувьд сөрөг нэхэмжлэл, хариуцагчийн тайлбар эсвэл суутган тооцуулах зорилготой нэхэмжлэлийн хариуцагчийн тайлбарыг гаргахаас өмнө уг гомдлыг гаргана. Аль нэг тал арбитрийг томилсон, эсвэл томилоход оролцсон байхаас үл хамааран энэ гомдлыг гаргаж болно. Аль нэг тал арбитрын бүрэлдэхүүн эрх хэмжээгээ хэтрүүлж байна гэсэн гомдлыг арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрх хэмжээгээ хэтрүүлсэн гэсэн асуудлыг дэвшүүлснээс хойш нэн даруй гаргана. Арбитрын бүрэлдэхүүн аль ч тохиодолд хойшлуулсан нь үндэслэлтэй байна гэж үзвэл сүүлд гаргасан гомдлыг хүлээн авч болно.

3. Арбитрын бүрэлдэхүүн энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гомдлыг урьдчилсан асуудлын хүрээнд эсвэл хэргийн агуулгын хувьд гаргасан шийдвэрийн хүрээнд шийдвэрлэж болно.

**24 дүгээр зүйл. Нэмэлт бичгэн баримтууд**

Арбитрын бүрэлдэхүүн талуудаас нэхэмжлэл болон тайлбар дээр нэмэлт ямар мэдэгдлийг бичгээр өгөх эсвэл танилцуулах шаардлагатай гэдгийг шийдвэрлэх бөгөөд эдгээрийг хүргүүлэх хугацааг тогтооно.

**25 дугаар зүйл. Хугацаа**

Арбитрын бүрэлдэхүүнээс бичгэн баримтыг (үүний дотор нэхэмжлэл болон хариуцагчийн тайлбар) хүргүүлэх хугацааг тогтоохдоо 45 хоногоос хэтрэхгүй байна. Гэвч арбитрын бүрэлдэхүүн хугацааг сунгах нь үндэслэлтэй гэж үзвэл хугацааг сунгаж болно.

**26 дугаар зүйл. Шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ**

1. Арбитрын бүрэлдэхүүн аль нэг талын хүсэлтээр шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг авч болно.

2. Шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ гэдэгт түр арга хэмжээг хэлэх бөгөөд үүгээр эцсийн шийдвэр гаргахаас өмнө аль ч үе шатанд арбитрын бүрэлдэхүүн аль нэг талд, тухайлбал, дараах үүрэг даалгаврыг өгч болох бөгөөд

эдгээр нь үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- (a) Маргааныг эцэслэн шийдвэрлэх хүртэл одоогийн байгаа байдлаа хадгалах эсвэл сэргээх;
- (b) (i) Арбитрын ажиллагаанд саад учруулах буюу шууд хор хохирол эсвэл (ii) ялгаварлах байдал үүсгэж болох аливаа үйлдэл хийхээс зайлсхийх;
- (c) Арбитрын шийдвэрийг хангахад хэрэглэгдэж болох хөрөнгийг хадгалах арга хэмжээ авах;
- (d) Маргааныг шийдвэрлэхэд ач холбогдолтой, үнэн зөв нотлох баримтыг хадгалах.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн “a”-аас “c” хүртэл заасан шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авахыг хүссэн тал нь арбитрын бүрэлдэхүүний өмнө дараах нөхцлийг хангасан байна. Үүнд:

- (a) Хэрэв тухайн арга хэмжээг аваагүй тохиолдолд хохирол арилгуулах тухай шийдвэрээр хохирлыг хангалттай барагдуулах боломжгүй бөгөөд тухайн арга хэмжээг авснаар уг хохирлын хэмжээ нь хариуцагчид учрах хохирлын хэмжээнээс нилээд хэмжээгээр давсан; болон
- (b) Хүсэлт гаргагч талын нэхэмжлэлийн шаардлага хангагдах магадлал өндөр байгаа. Ийнхүү магадлалыг тогтоох нь арбитрын бүрэлдэхүүний цаашдын шийдвэр гаргах үзэмжид нөлөөлөхгүй.

4. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн “d”-д заасан шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авахуулах тухай хүсэлтийн хувьд энэ зүйлийн 3 дахь хэсгийн “a” болон “b”-д заасан шаардлагыг арбитрын бүрэлдэхүүн тохиромжтой гэж үзсэн тохиолдолд л хамаарна.

5. Арбитрын бүрэлдэхүүн нь өөрийн санаачилгаар өөрийн олгосон шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг аль нэг тал өргөдөл гаргаснаар, эсвэл онцгой тохиолдолд талуудад урьдчилсан мэдэгдэл хүргүүлснээр өөрчилж, гүйцэтгэлийг түдгэлзүүлж, зогсоож болно.

6. Арбитрын бүрэлдэхүүн шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг авахыг хүссэн талыг уг арга хэмжээтэй холбоотойгоор зохих гүйцэтгэх арга хэмжээ авахыг үүрэг болгож болно.

7. Арбитрын бүрэлдэхүүн аль нэг талыг шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авахыг хүсэх эсвэл олгох үндэслэл болсон хэргийн нөхцөл байдал эрс өөрчлөгдсөнийг нэн даруй мэдэгдэхийг шаардаж болно.

8. Хэрэв арбитрын бүрэлдэхүүн сүүлд тухайн нөхцөл байдалд шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг олгох ёсгүй байсан гэж тогтоосон бол ийнхүү арга хэмжээ авах тухай хүсэлт гаргасан тал нөгөө талд эдгээрээс үүдэн гарсан

аливаа зардал, хохирлыг арилгах үүрэгтэй. Арбитрын бүрэлдэхүүн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед зардал болон хохирлыг арилгуулах тухай шийдвэр гаргаж болно.

9. Аль нэг талаас шүүхийн байгууллагад шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авах хүсэлтийг гаргасан нь маргаанаа арбитраар шийдвэрлүүлэх тохиролцоотой нийцэхгүй гэж үзэхгүй, эсвэл арбитрын хэлэлцээрээс татгалзсан гэж үзэхгүй.

### **27 дугаар зүйл. Нотлох баримт**

1. Талууд тус бүр өөрийн нэхэмжлэл эсвэл тайлбарыг бататгахад үндэслэсэн баримтыг нотлох үүрэг хүлээнэ.

2. Арбитрын бүрэлдэхүүнд талуудаас ямар нэгэн баримт эсвэл мэргэжлийн дүгнэлт гаргуулах, мэдүүлэг өгөхөөр оруулсан гэрч, шинжээч арбитрын ажиллагааны тал болсон эсвэл аль нэг талтай ямар нэгэн харилцаа холбоотой эсэхийг үл харгалзан ямар ч хүн байж болно. Арбитрын бүрэлдэхүүнээс өөр чиглэл өгөөгүй бол гэрч, шинжээчийн мэдүүлгийг бичгээр, гарын үсэг зуруулж танилцуулна.

3. Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд арбитрын бүрэлдэхүүн талуудаас тогтоосон хугацаанд баримт бичиг, бодит нотлох баримт эсвэл бусад нотлох баримтыг гаргахыг шаардаж болно.

4. Арбитрын бүрэлдэхүүн санал болгосон нотлох баримтыг тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, материаллаг болон эзлэх хувийн жин зэргийг үнэлнэ.

### **28 дугаар зүйл. Арбитрын хуралдаан**

1. Арбитрын хэргийг уншин сонсох бол арбитрын бүрэлдэхүүн талуудад хуралдааны огноо, цаг болон газрын тухай мэдээллийг хангалттай хугацаанд урьдчилан мэдээлнэ.

2. Гэрчүүд болон шинжээчид арбитрын бүрэлдэхүүнээс тогтоосон нөхцөл болон хэлбэрээр мэдүүлэг өгч болно.

3. Талууд өөрөөр тохиролцоогүй бол хуралдааныг камерын бичлэгтэй явуулны. Арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагааны тал болсон гэрч болон шинжээчийг зарчмын хувьд хурлын танхимаас гарах хүсэлтийг гаргаагүйгээс бусад тохиолдолд өөр ижил гэрч, шинжээчийн мэдүүлгийн үеэр гэрч(үүд) болон шинжээчдийг хурлын танхимаас гарахыг шаардаж болно.

4. Арбитрын бүрэлдэхүүн гэрч, шинжээчийг хуралдааны үеэр биеэр байх шаардлагүйгээр онлайн хэлбэрээр мэдүүлэг өгөх заавар өгч болно (жишээ нь, видео-конференц).

### **29 дүгээр зүйл. Арбитрын бүрэлдэхүүнээс томилогдсон шинжээчид**

1. Талуудтай зөвшилцсөний дараа арбитрын бүрэлдэхүүн нэг эсвэл түүнээс дээш тооны шинжээчийг арбитрын бүрэлдэхүүнээс тогтоосон тодорхой асуудлаар өөрт бичгээр тайлагнахыг үүрэг болгож болно. Талуудад арбитрын бүрэлдэхүүнээс тогтоосон шинжээчийн ажлын удирдамжийн хуулбарыг хүргүүлнэ.

2. Шинжээч нь зарчмын хувьд тухайн томилгоог хүлээн авахын өмнө арбитрын бүрэлдэхүүн болон талуудад өөрийн мэргэшил болон өөрийн бие даасан, хараат бус байдлын талаарх мэдэгдэлийг хүргүүлнэ. Арбитрын бүрэлдэхүүнээс тогтоосон хугацаанд талууд арбитрын бүрэлдэхүүнд шинжээчийн мэргэшил, түүний бие даасан, хараат бус байдалд гаргах аливаа татгалзлыг мэдэгдэнэ. Арбитрын бүрэлдэхүүн энэ татгалзлыг хүлээн авах эсэхийг нэн даруй шийдвэрлэнэ. Шинжээч томилогдсоны дараа аль нэг тал шинжээчийн мэргэшил, түүний бие даасан, хараат бус байдалд гагцхүү шинжээчийн томилогдсоны дараа мэдсэн аливаа шалтгаанаар татгалзлаа гаргаж болно. Арбитрын бүрэлдэхүүн ямар нэг үйлдэл хийх эсэхийг нэн даруй шийдвэрлэнэ.

3. Талууд шинжээчийн шаардсаны дагуу хэрэгт холбогдолтой мэдээлэл өгөх, баримт бичиг, бараа материалд үзлэг хийх боломж олгоно. Аль нэг тал болон шинжээчийн хооронд шаардсан мэдээлэл эсвэл гаргуулах баримт бичиг, бараа материалын хэрэгт хамаарах ач холбогдлын талаар гарсан аливаа маргааныг арбитрын бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.

4. Шинжээчийн дүгнэлтийг хүлээн авсны дараагаар арбитрын бүрэлдэхүүн талуудад дүгнэлтийн хуулбарыг хүргүүлэх бөгөөд ингэснээр талуудад дүгнэлтэд өөрийн саналаа бичгээр илэрхийлэх боломжийг олгоно. Аль нэг тал дүгнэлтээ гаргахдаа үндэслэл болгосон аливаа баримт бичгийг шинжлэх эрхтэй байна.

5. Аль нэг талын хүсэлтээр шинжээч нь дүгнэлтээ гаргасныхаа дараа арбитрын хуралдаанд оролцож, талуудын тавьсан асуултад шинжээч хариулах боломжийг олгоно. Энэ хуралдаанд аль нэг тал тухайн асуудлаар мэдүүлэг өгүүлэхээр шинжээчийг оруулж болно. 28 дугаар зүйл энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарна.

### **30 дугаар зүйл. Үүргээ үл биелүүлэх**

1. Хэрэв энэ Дүрэм эсвэл арбитрын бүрэлдэхүүнээс тогтоосон хугацаанд хангалттай үндэслэл дэвшүүлэлгүйгээр:

- (a) Нэхэмжлэгч нэхэмжлэлээ ирүүлээгүй бол шийдвэрлэх шаардлагатай зарим асуудал үлдсэн бөгөөд арбитрын бүрэлдэхүүнээс эдгээрийг шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагааг дуусгавар болгох тухай шийдвэр гаргана;
- (b) Хариуцагч арбитрын ажиллагааны хүсэлтийн хариу эсвэл өөрийн тайлбарыг ирүүлээгүй бол арбитрын бүрэлдэхүүнээс ийнхүү ирүүлээгүй нь нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэлгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх

шийдвэр гаргана; энэ хэсэгт заасан зүйл нь нэхэмжлэгчийн сөрөг нэхэмжлэлд хариуцагч тайлбар өгөөгүй эсвэл суутган тооцох зорилготой нэхэмжлэлд хариу өгөөгүй зэрэг тохиолдлуудад мөн адил үйлчилнэ.

2. Хэрэв аль нэг тал энэ Дүрмийн дагуу зохих ёсоор мэдэгдсэн хэдий ч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд ирээгүй тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагааг үргэлжлүүлж болно.

3. Хэрэв аль нэг тал арбитрын бүрэлдэхүүнээс зохих ёсоор бичиг баримт, бодит нотлох баримт болон бусад нотлох баримтыг гаргаж өгөх хүсэлтийг хүлээн авсан хэдий ч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тогтсон хугацаанд эдгээрийг гаргаж өгөөгүй бол арбитрын бүрэлдэхүүн өөрт байгаа нотлох баримтын хүрээнд шийдвэр гаргаж болно.

### **31 дүгээр зүйл. Арбитрын хуралдааныг хаах**

1. Арбитрын бүрэлдэхүүн талуудаас нэмэлт нотлох баримт гаргах, гэрчийг дуудах эсвэл нэмэлт материал өгөх эсэхийг асуух бөгөөд ингэхгүй бол арбитрын хуралдааныг хаасныг зарлаж болно.

2. Арбитрын бүрэлдэхүүн онцгой нөхцөл байдлын улмаас шаардлагатай гэж үзвэл өөрийн санаачилгаар эсвэл аль нэг талын хүсэлтээр арбитрын шийдвэр гаргахаас өмнө аль ч үед хуралдааныг дахин нээж болно.

### **32 дугаар зүйл. Татгалзах эрхээсээ татгалзах**

Хэрэв аль нэг тал тухайн нөхцөл байдалд татгалзлаа мэдэгдээгүй нь үндэслэлтэй гэдгийг харуулж чадахгүй бол талууд энэ Дүрэм эсвэл арбитрын хэлэлцээрийн аль нэг шаардлагыг биелүүлээгүйг нэн даруй татгалзаагүй бол тухайн тал нь энэ талаар татгалзах эрхээсээ татгалзсанд тооцно.

## **Дөрөвдүгээр бүлэг. Арбитрын шийдвэр**

### **33 дугаар зүйл. Шийдвэрүүд**

1. Хэргийг нэгээс илүү арбитрч шийдвэрлэж байгаа тохиолдолд арбитрын бүрэлдэхүүнээс гарах аливаа арбитрын шийдвэр болон бусад шийдвэрүүдийг олонхийн саналаар гаргана.

2. Журмын талаар асуулт гарвал олонхи болохгүй эсвэл арбитрын бүрэлдэхүүн эрх мэдэл олгосон тохиолдолд даргалагч арбитрч дангаар шийдвэрлэж болох бөгөөд энэ шийдвэрт арбитрын бүрэлдэхүүнээс засвар оруулж болно.

### **34 дүгээр зүйл. Арбитрын шийдвэрийн хэлбэр болон үр нөлөө**

1. Арбитрын бүрэлдэхүүн өөр өөр асуудлаар өөр өөр хугацаанд тусдаа шийдвэр гаргаж болно.

2. Бүхий л шийдвэрийг бичгээр үйлдэх бөгөөд үүнийг талууд заавал дагаж

мөрдөх үүрэгтэй. Талууд бүхий л шийдвэрийг хугацаа алдалгүйгээр биелүүлнэ.

3. Талууд үндэслэл заах шаардлагагүй гэдэг дээр санал нэгдсэнээс бусад тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн шийдвэрийн үндэслэлийг заана.

4. Арбитрчид шийдвэрт гарын үсэг зурах бөгөөд үүнд шийдвэр гарсан огноо болон арбитрын ажиллагаа явуулсан газрыг заана. Арбитрын бүрэлдэхүүн нэгээс илүү арбитрчаас бүрдсэн бөгөөд арбитрчид нь бүгд гарын үсгээ зураагүй бол шийдвэрт гарын үсэг зурагдаагүй шалтгааныг заана.

5. Талуудын хүсэлтээр буюу аль нэг талын хуулиар хүлээсэн үүргийн дагуу, хуулиар олгосон эрхийг хамгаалах буюу хангах эсвэл шүүх буюу бусад эрх бүхий байгууллагын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор шийдвэрийг нийтэд ил болгож болно.

6. Арбитрын бүрэлдэхүүн арбитрчийн гарын үсэгтэй шийдвэрийн хуулбарыг талуудад гардуулна.

### **35 дугаар зүйл. Холбогдох хууль, нөхөрсөг зохицуулагч**

1. Арбитрын бүрэлдэхүүн хэргийн агуулгад тохирох хэмжээгээр талуудын сонгосон эрх зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө. Талууд ийнхүү сонгоогүй бол арбитрын бүрэлдэхүүн тохиромжтой гэж үзсэн хуулийг хэрэглэнэ.

2. Зөвхөн талууд шууд эрх олгосон тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн *нөхөрсөг зохицуулагч* эсвэл *ex aequo et bono*-ийн үүргийг гүйцэтгэнэ.

3. Аль ч тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн хэргийг шийдвэрлэхдээ талуудын хооронд байгуулсан гэрээ болон тухайн хэлцлийн талаар тогтсон худалдааны заншлын хэм хэмжээг баримтлана.

### **36 дугаар зүйл. Талууд эвлэрэх эсвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох бусад үндэслэл**

1. Хэрэв арбитрын шийдвэр гарахаас өмнө талууд эвлэрэхээр санал нэгдсэн бол арбитрын бүрэлдэхүүн нэг бол арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох тухай шийдвэр гаргах эсвэл талуудын хүсэлтээр болон арбитрын бүрэлдэхүүн татгалзаагүй бол эвлэрсэн нөхцлийг тэмдэглэж арбитрын шийдвэр гаргана. Арбитрын бүрэлдэхүүн ийнхүү гаргасан шийдвэрт үндэслэлийг заах үүрэг хүлээхгүй.

2. Хэрэв арбитрын шийдвэр гарахаас өмнө энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдаагүй шалтгаанаар арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх нь шаардлагагүй эсвэл боломжгүй болсон бол арбитрын бүрэлдэхүүн талуудад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох тухай шийдвэр гаргах эрмэлзэлтэй байгаага талуудад мэдэгдэнэ. Аливаа үлдсэн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай бөгөөд арбитрын бүрэлдэхүүнээс ийнхүү шийдвэрлэх нь зохистой гэж үзсэнээс бусад тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн энэ шийдвэрийг гаргах эрх мэдэлтэй байна.



3. Арбитрчдын гарын үсэгтэй арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох тухай шийдвэр эсвэл талуудын эвлэрсэн нөхцлийг тэмдэглэсэн арбитрын шийдвэрийн хуулбарыг арбитрын бүрэлдэхүүнээс талуудад хүргүүлнэ. Талуудын эвлэрсэн нөхцлөөр арбитрын шийдвэр гарсан тохиолдолд 34 дүгээр зүйлийн 2, 4, 5 дахь хэсэг хамаарна.

**37 дугаар зүйл. Арбитрын шийдвэрийг тайлбарлах**

1. Шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор аль нэг тал нөгөө талдаа мэдэгдсэнээр арбитрын бүрэлдэхүүнээс шийдвэрийг тайлбарлах хүсэлт гаргаж болно.

2. Хүсэлтийг хүлээн авснаас хойш 45 хоногийн дотор тайлбарыг бичгээр хүргүүлнэ. Тайлбар нь шийдвэрийн нэг хэсэг болох бөгөөд 34 дүгээр зүйлийн 2-оос 6 дахь хэсгийн заалтууд хамаарна.

**38 дугаар зүйл. Арбитрын шийдвэрт засвар оруулах**

1. Арбитрын шийдвэр хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор аль нэг тал нөгөө талдаа мэдэгдэн арбитрын бүрэлдэхүүнд арбитрын шийдвэрт гарсан тооцооны, техникийн, эсвэл хэвлэлийн болон түүнтэй төсөөтэй бусад алдааг засуулахаар хүсэлт гаргаж болно. Хэрэв арбитрын бүрэлдэхүүн энэ хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл хүсэлтийг хүлээн авснаас хойш 45 хоногийн дотор засварыг оруулна.

2. Арбитрын бүрэлдэхүүн шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор өөрийн санаачлагаар энэ төрлийн алдааг залруулж болно.

3. Энэ засварыг бичгээр үйлдэх бөгөөд энэ нь арбитрын шийдвэрийн бүрэлдэхүүн хэсэг болно. Үүнд 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсгээс 6 дахь хэсэг хамаарна.

**39 дүгээр зүйл. Нэмэлт шийдвэр**

1. Аль нэг тал нөгөө талд мэдэгдэн арбитрын шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор арбитрын бүрэлдэхүүнээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр танилцуулсан боловч арбитрын бүрэлдэхүүнээс шийдвэрлээгүй шаардлагын талаар шийдвэр эсвэр нэмэлт шийдвэр гаргуулахыг хүсэж болно.

2. Хэрэв арбитрын бүрэлдэхүүн шийдвэр эсвэл нэмэлт шийдвэр гаргах хүсэлт нь үндэслэлтэй гэж үзвэл хүсэлтийг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор шийдвэрээ эсвэл нэмэлт шийдвэр гаргана. Арбитрын бүрэлдэхүүн шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах хугацааг сунгаж болно.

3. Энэ шийдвэр эсвэл нэмэлт шийдвэр гарсан тохиолдолд 34 дүгээр зүйлийн 2-оос 6 дахь хэсэг хамаарна.

**40 дүгээр зүйл. Зардлын тодорхойлолт**

1. Арбитрын бүрэлдэхүүн арбитрын зардлыг эцсийн шийдвэрт, мөн

шаардлагатай гэж үзвэл өөр шийдвэрт тогтооно.

2. “Зардал” гэдэг нэр томъёонд гагцхүү дараах зүйлийг тусгана. Үүнд:

- (a) Арбитрын бүрэлдэхүүний хураамжийг арбитрч тус бүрээр тусад нь заах бөгөөд үүнийг арбитрын бүрэлдэхүүн өөрөө 41 дүгээр зүйлийн дагуу тогтооно;
- (b) Арбитрчийн үндэслэл бүхий аялал болон бусад холбогдох зардал;
- (c) Арбитрын бүрэлдэхүүнээс мэргэжлийн зөвлөгөө болон бусад туслалцаа үзүүлэхэд гарсан үндэслэл бүхий зардал;
- (d) Арбитрын бүрэлдэхүүнээс зөвшөөрсөн хэмжээгээр гэрчийн үндэслэл бүхий аялалын зардал болон бусад холбогдох зардал;
- (e) Арбитрын бүрэлдэхүүнээс тухайн зардлын үнийн дүн үндэслэлтэй гэж үзсэнтэй нийцэх хэмжээгээр талуудаас гарсан хууль зүйн болон бусад зардал;
- (f) Томилох эрх бүхий байгууллага болон АБШ-ийн Ерөнхий нарийн бичгийн даргын аливаа зардал, хураамж.

3. Арбитрын шийдвэрийг 37-оос 39 дүгээр зүйлд заасны дагуу тайлбарлах, засвар оруулах эсвэл эцэслэн гаргахтай холбоотойгоор арбитрын бүрэлдэхүүнээс энэ зүйлийн 2 дахь хэсгийн “b”-ээс 2 дахь хэсгийн “f”-д заасан нэмэлт зардлыг тооцож болно. Гэвч үүнээс илүү хураамж авахгүй.

#### **41 дүгээр зүйл. Арбитрын хураамж болон арбитрчийн зардал**

1. Маргааны үнийн дүн, хэргийн нарийн төвөгтэй байдал, арбитрчийн зарцуулсан цаг хугацаа болон бусад холбогдох нөхцөл байдал зэргийг харгалзан арбитрын хураамж болон арбитрчийн зардал нь үндэслэлтэй байна.

2. Хэрэв томилох эрх бүхий байгууллага байгаа бөгөөд энэ нь олон улсын маргаанд арбитрчийн хураамжийг тооцох хуваарь эсвэл тодорхой аргачлалыг хэрэглэдэг эсвэл хэрэглэнэ гэж мэдэгдсэн бол арбитрын бүрэлдэхүүн өөрийн хураамжаа тогтоохдоо хэргийн нөхцөл байдлаас хамааран шаардлагатай гэж үзвэл энэ хуваарь эсвэл аргачлалыг харгалзаж үзнэ.

3. Арбитрын бүрэлдэхүүн байгуулагдсан даруйдаа талуудад хураамж болон зардлыг хэрхэн тооцох саналтай байгаа тухайгаа мэдэгдэх бөгөөд үүнд мөн аливаа хүүг тооцох асуудал хамаарна. Энэ саналыг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор аль нэг талаас тухайн саналыг томилох эрх бүхий этгээдэд хянуулахаар хандаж болно. Хэрэв ийнхүү хүсэлтийг хүлээн авснаас хойш 45 хоногийн дотор томилох эрх бүхий этгээд арбитрын бүрэлдэхүүний санал нь энэ зүйлийн 1 дэх хэсэгтэй нийцэхгүй байна гэж үзвэл шаардлагатай өөрчлөлтийг оруулах бөгөөд үүнийг арбитрын бүрэлдэхүүн заавал дагаж мөрдөх үүрэгтэй.

- 4. (a) 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “a” болон “b” хэсэгт заасны

дагуу тогтоосон арбитрчийн хураамж болон зардлыг талуудад мэдэгдэхдээ арбитрын бүрэлдэхүүн холбогдох үнийн дүнг хэрхэн тооцсоныг тайлбайрлана;

- (b) Арбитрын бүрэлдэхүүнээс тогтоосон хураамж болон зардлыг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор аль нэг тал ийнхүү тогтоосныг томилох эрх бүхий этгээдээр хянуулахаар хүсэлт гаргаж болно. Хэрэв томилох эрх бүхий этгээдийг тохиролцоогүй эсвэл томилоогүй, эсвэл томилох эрх бүхий этгээд энэ Дүрэмд заасан хугацаанд аливаа үйлдэл хийгээгүй бол хянах үүргийг АБШ-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ;
- (c) Хэрэв томилох эрх бүхий этгээд эсвэл АБШ-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга арбитрын бүрэлдэхүүний тогтоосон нь энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан арбитрын бүрэлдэхүүний санал (болон аливаа засвар)-тай нийцэхгүй байна гэж үзсэн эсвэл илэрхий өндөр байна гэж үзвэл энэ хүсэлтийг хүлээн авснаас хойш 45 хоногийн дотор арбитрын бүрэлдэхүүний тогтоосон үнийн дүнд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангах ёстой аливаа засварыг хийнэ. Ийнхүү хийсэн аливаа засварыг арбитрын бүрэлдэхүүн заавал дагаж мөрдөх үүрэгтэй;
- (d) Аливаа засварыг арбитрын бүрэлдэхүүн өөрийн шийдвэртээ оруулах буюу хэрэв арбитрын шийдвэрийг гаргасан бол шийдвэрийг залруулах бөгөөд ингэхдээ 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журам үйлчилнэ.

5. Энэ зүйлийн 3 болон 4 дэх хэсэгт заасан журмын дагуу арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагааг 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу явуулна.

6. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан хүсэлт нь арбитрын шийдвэрт арбитрын бүрэлдэхүүний хураамж болон зардлыг тооцохоос өөр хэсэгт хамаарахгүй; мөн энэ нь арбитрын хураамж болон зардлыг тооцохдоо холбоотой арбитрын шийдвэрийн хэсгээс үлдсэн бусад хэсгийг хүлээн зөвшөөрөх болон биелүүлэхийг хойшлуулах үндэслэл болохгүй.

#### **42 дугаар зүйл. Зардлын хуваарилалт**

1. Арбитрын зардлыг зарчмын хувьд ялагдсан тал(ууд) хариуцна. Гэсэн хэдий ч хэрэв арбитрын бүрэлдэхүүн хэргийн нөхцөл байдлыг харгалзан талуудын дунд зардлыг тэнцүү хуваарилах нь үндэслэлтэй гэж үзвэл энэ зардлыг тус бүр тэнцүү хуваарилж болно.

2. Арбитрын бүрэлдэхүүн эцсийн шийдвэртээ эсвэл шаардлагатай гэж үзвэл бусад шийдвэртээ зардлыг хуваарилахтай холбогдуулан аль нэг талыг нөгөө талдаа төлөх ёстой аливаа үнийн дүнг тогтооно.

#### **43 дугаар зүйл. Зардлын урьдчилгаа төлбөрийг төлөх**

1. Арбитрын бүрэлдэхүүн байгуулагдсаны дараа талуудаас 40 дүгээр зүйлийн 2

дахь хэсгийн (а)-аас (с)-д заасан зардлын урьдчилгаа болгон ижил хэмжээний төлбөрийг авч болно.

2. Арбитрын ажиллагааны явцад арбитрын бүрэлдэхүүн талуудаас нэмэлт төлбөрийг урьдчилгаа төлбөрт авч болно.

3. Хэрэв томилох эрх бүхий этгээдийг харилцан тохиролцсон эсвэл томилогдсон бөгөөд аль нэг тал хүсэлт гаргасан ба томилох эрх бүхий этгээд тухайн үүргийг биелүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн гагцхүү томилох эрх бүхий этгээдтэй зөшилцсөний үндсэн дээр урьдчилгаа төлбөрийн хэмжээ эсвэл нэмэлт урьдчилгаа төлбөрийг тогтоох бөгөөд энэ тохиолдолд томилох эрх бүхий этгээд арбитрын бүрэлдэхүүнд шаардлагатай гэж үзвэл урьдчилгаа төлбөр болон нэмэлт урьдчилгаа төлбөрийн талаар ямар нэгэн тайлбар гаргаж болно.

4. Хэрэв шаардлагатай урьдчилгаа төлбөрийг хүсэлт хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор бүрэн төлөөгүй тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн нэг ба түүнээс дээш тооны талуудад шаардлагатай төлбөрийг төлөх боломж олгохын тулд энэ тухай мэдэгдэнэ. Хэрэв энэ төлбөрийг хийгээгүй тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх эсвэл дуусгавар болгох тухай шийдвэр гаргаж болно.

5. Дуусгавар болгох буюу эцсийн шийдвэр гарсны дараа арбитрын бүрэлдэхүүн талуудаас авсан урьдчилгаа төлбөрийн тооцоог гаргаж өгөх бөгөөд аливаа тооцоолоогүй үлдэгдэл мөнгийг талуудад буцаана.